

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундестагийн сонгуулийн дүн ба өнөөгийн байдал

Доктор (Sc.D) Олхонууд Р.Жамц

ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

ХБНГУ-ын Канцлер Герхард Шредер хоёр дахь удаагаа сонгогдон ажиллах хугацаа нь хараахан дуусаагүй үед буюу ХБНГУ-ын нийгэм, эдийн засгийн байдал түр зуурийн бэрхшээлтэй тулгарсан үе болох 2005 оны IX сард ХБНГУ-д Бундестагийн сонгууль болж өнгөрлөө.

Сонгуулийн үед Германд хамгийн анхаарал татаж байсан асуудал бол Шредерийн Засгийн газраас 2003 онд дэвшүүлсэн "2010 он-цаг үеийн асуудал" хэмээх өөрчлөлт шинэчлэлтийн хөтөлбөр юм. Энэхүү хөтөлбөрийг Шредер хоёрдахь удаагаа Засгийн газрыг толгойлон ажиллаж эхлэхдээ дэвшүүлсэн нь анхаарал татаж байгаа төдийгүй уг хөтөлбөр бодит амьдрал дээр хэрэгжих боломж хэр зэрэг байна вэ гэсэн асуулт зүй ёсоор тавигдаж байв. Одоо ХБНГУ-д явагдаж буй өөрчлөлтүүд нь Герман орныг эдийн засаг, нийгмийн түр зуурын бэрхшээл бухимдлаас гаргах зам мөн үү эсвэл ХХ зуунд хамгийн амжилттай хэрэгжиж олны анхаарал татсан нийгмийн баримжаатай, зах зээлийн эдийн засгийн хөгжлийн Герман загварыг нураана гэсэн үг юм уу хэмээх эргэлзлийг төрүүлж, сөрөг хүчний хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсан юм.

Сонгууль болох тухайн үед ХБНГУ дэлхийн зах зээл дээр өөрийн өрсөлдөх давуу талуудаа алдах шинж тодорч, глобальчлалын асуудлуудад хариу өгч чадахаа больж эхэлж байлаа. ХБНГУ Европын Холбооны олон хамтрагч нараа урдаа оруулсан төдийгүй АНУ-тай харьцуулбал хөгжлийн хурд, хөгжлийн түвшингээрээ хэд дахин доогуур байв. Сүүлийн 3-4 жилийн дотор Англи, Франц, Австри бүр Нидерланд хүртэл 1 хүнд ноогдох ҮНБ-ний үйлдвэрлэлийн хэмжээгээр Германыг гүйцэж түрүүлээд байна. Германы эдийн засаг бүтцийн хямралд орж, удаан хугацааны туршид тэнд ажилгүйдэл өндөр түвшинд байв. Улсын санхүүгийн тогтолцоо нь хөгжлийг хөхүүлэн дэмжихийн оронд түүнд саад учруулагч хүчин зүйл болж хувираад байлаа.

Үүнээс гадна хүн амын асуудал хурцаар тавигдах болов. Хүн амын хөгшрөлт явагдаж, төрөлт багассан. Тухайлбал, одоогийн тооцоогоор

2020 он гэхэд Германы иргэдийн насны дундаж үзүүлэлт 46.7¹ нас болох байхад АНУ-д энэ тоо 37 байх аж. 2050 он гэхэд Германы хүн ам 77 саяд хүрэх буюу одоогийнхоос 5 саяар буурах прогноз байна. Энэ бүхэн өөрчлөлтийг цогцолбороор нь хийхэд хүргэж байна.

Хамгийн гол санаа зовоож буй асуудал бол үр ашигтай болохоо харуулсан тогтолцоог нураалгүйгээр хэрхэн өөрчлөх вэ гэдэг асуудал юм. Мэдээж Германы иргэд бүгдээрээ бус гэхэд дийлэнх олонх нь нийгмийн баримжаатай, зах зээлийн эдийн засгийн тогтолцоогоо хадгалах эрмэлзлэлтэй байгаа нь ойлгомжтой. Гэвч амжилтанд хүрнэ гэсэн тэдний итгэл багассаар байна. Эдийн засгийн бүтцийн хямрал гол нь өсөлтийн бага хурдаар илэрч, 1992 оноос хойш эдийн засгийн өсөлт дунджаар 2-иос доош хувьтай байлаа. 2000 онд эдийн засгийн өсөлт хамгийн өндөр хувьтай буюу 2,9% байсан нь Шредерийн багыг баярлуулсан хэдий ч дахин буурч, удаахь 3 жилд эдийн засгийн өсөлт 0,8%, 0,9%, 0,1% тус тус байв.²

1994 оноос хойш ажилгүйдлийн түвшин ажиллах чадвартай хүн амын 10 хувиас доош буугаагүй бөгөөд энэ нь зөвхөн бүртгэлтэй ажилгүйчүүд юм. Зүүн Германы мужуудад энэ үзүүлэлт 18,5%-19,5%-ийн хооронд хэлбэлзэж байлаа. 2004 оны III сарын байдлаар албан ёсоор бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоо 4,5 сая-д хүрсэн байв. Сүүлийн үед Германы том том компаниуд, тэдний араас жижиг, дунд пүүсүүд ажлын байраа гадагш гаргах нь ихсэж байна. Үүний гол шалтгаан бол хөдөлмөрийн өндөр өртөг, ажлын байрны өндөр үнэ бөгөөд 2003 онд Германы аж ахуйн газруудын 1/4 нь ойрын 3 жилд үйлдвэрлэлээ гадаад руу шилжүүлж гаргана гэж мэдэгдсэн. Жишээ нь Германы дэлхийд нэртэй "Сийменс" концерний охин компани "Сиймэнс Ай-Си-Эн" сүүлийн 3 жилд Хятад, Солонгос, Чех, Унгар зэрэг орнуудад үйлдвэрлэлээ шилжүүлснээр Герман дахь ажлын байраа 20.000-аар хорогдуулжээ. Энэ нь байнгын шинж чанартай болж буй ажээ. Германд капиталын гадагш гаралт 2001 онд 26,69 тэрбум евро, 2003 онд 55 тэрбум еврод хүрсэн байна.³

Герман улсад хөрөнгө оруулалт идэвхгүй, сул байгаа бөгөөд сүүлийн 3 жилд тоног төхөөрөмжид хийх хөрөнгө оруулалт 3%-8%-иар буурсан бол барилга угсралтын салбарт үүнээс ч дор байв. Шинжлэх ухаан, техник, технологийн шинэчлэлд зарцуулах зардал ДНБ-тэй харьцуулан үзэхэд өсөлтгүй байна.

¹ *Вестник Европы, XV том, 2005, 69 дүгээр тал*

² *мөн тэнд*

³ *мөн тэнд*

Ийм таагүй нөхцөл байдалд Шредерийн Засгийн газар өөрчлөлт шинэчлэлээ хийж эхэлсэн юм. Хэдийгээр өөрчлөлт, шинэчлэлийн хөтөлбөрийг 80-аад оны сүүлчээр Х.Колийн Засгийн газар эхлүүлсэн ч цогц арга хэмжээ болж чадаагүй байлаа. Засгийн эрхэнд гарангуут Шредер өөрчлөлт шинэчлэлийг цогцоор нь хараахан хийж эхлээгүй үед олон асуудалтай тулгарсан бөгөөд өөрчлөлтийг зөвхөн эдийн засаг, нийгмийн салбар руу чиглүүлэн хязгаарласны зэрэгцээ татвар болон тэтгэврийн өөрчлөлтийг зэрэг хийхээр бэлтгэж эхэлсэн байв. Зөвхөн 2001-2002 оны эдийн засгийн уналт л түүнийг өөрчлөлт шинэчлэлийг цогцоор нь хийхэд хүргэсэн байна.

2003 оны III сарын 14-нд Засгийн газар Бундестагт тусгай мэдэгдэл хийсэн нь хожим "2010 он-цаг үеийн асуудал" хэмээх өөрчлөлтийн хөтөлбөрийг бий болгожээ. Анхандаа уг хөтөлбөр нь дараах үндсэн арга хэмжээг багтааж байв. Үүнд:

нэгдүгээрт, хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлт

хоёрдугаарт, эрүүл мэндийн зайлшгүй даатгалын өөрчлөлт

гуравдугаарт, гар урлалын үйлдвэрлэлийн хууль эрхзүйн зохицуулалтын өөрчлөлт, нийтийн аж ахуйн санхүүгийн шинэчлэлт, орон нутгийн засаг захиргаанд зориулсан хямд зээлийн хөтөлбөр ба орон сууцны шинэчлэл зэрэг юм.

Хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлт нь хоёр үндсэн арга хэмжээг багтааж байв. Үүнд үндэслэлгүйгээр ажлаас халахын эсрэг уян хатан хамгаалалт хэрэглэх ба ажилгүйдлийн тэтгэмжийг хэмжээ болон хугацаагаар нь зохицуулах явдал орно. Мөн удаан хугацаагаар ажилгүй байсан тохиолдолд тэтгэмж болон нийгмийн тусламжийг тус тусад нь олгохыг зогсоож нэгтгэх тухай заажээ.

Эрүүл мэндийн зайлшгүй даатгалын хувьд үзүүлэх үйлчилгээний жагсаалт цөөрсөн байв. Мөн эмнэлэгт хэвтэх, эм худалдан авах зэрэг зарим үйлчилгээнд мөнгө нэмж төлөх тухай тусгай нэмэгдлүүд орсон байна. Энэ тогтолцоо 2004 оноос үйлчилж эхэлсэн бөгөөд сүүлийн үед интернет-аптекуудад зөвшөөрөл өгснөөр тэд хүчээ авч эхэлсэн нь ажиглагдаж байна.

Гар урлалын үйлдвэрлэлийн хуулинд зохицуулснаар гар урлалын үйлдвэрлэл нээх, худалдан авах явдал нэлээд либералчлагдахаар болж аливаа шат дамжлага багасах ажээ. Үүний зэрэгцээ татварын шат дараалсан шинэчлэлийг сэргээсэн байна.

2004 оны I сард эхэлсэн хоёрдугаар үе шат нь хүн амын албан татварыг бууруулахад чиглэжээ. Хүн амын албан татвар болон

2020 он гэхэд Германы иргэдийн насны дундаж үзүүлэлт 46,7¹ нас болох байхад АНУ-д энэ тоо 37 байх аж. 2050 он гэхэд Германы хүн ам 77 саяд хүрэх буюу одоогийнхоос 5 саяар буурах прогноз байна. Энэ бүхэн өөрчлөлтийг цогцолбороор нь хийхэд хүргэж байна.

Хамгийн гол санаа зовоож буй асуудал бол үр ашигтай болохоо харуулсан тогтолцоог нураалгүйгээр хэрхэн өөрчлөх вэ гэдэг асуудал юм. Мэдээж Германы иргэд бүгдээрээ бус гэхэд дийлэнх олонх нь нийгмийн баримжаатай, зах зээлийн эдийн засгийн тогтолцоогоо хадгалах эрмэлзлэлтэй байгаа нь ойлгомжтой. Гэвч амжилтанд хүрнэ гэсэн тэдний итгэл багассаар байна. Эдийн засгийн бүтцийн хямрал гол нь өсөлтийн бага хурдаар илэрч, 1992 оноос хойш эдийн засгийн өсөлт дунджаар 2-иос доош хувьтай байлаа. 2000 онд эдийн засгийн өсөлт хамгийн өндөр хувьтай буюу 2,9% байсан нь Шрёдерийн багыг баярлуулсан хэдий ч дахин буурч, удаахь 3 жилд эдийн засгийн өсөлт 0,8%, 0,9%, 0,1% тус тус байв.²

1994 оноос хойш ажилгүйдлийн түвшин ажиллах чадвартай хүн амын 10 хувиас доош буугаагүй бөгөөд энэ нь зөвхөн бүртгэлтэй ажилгүйдчүүд юм. Зүүн Германы мужуудад энэ үзүүлэлт 18,5%-19,5%-ийн хооронд хэлбэлзэж байлаа. 2004 оны III сарын байдлаар албан ёсоор бүртгүүлсэн ажилгүйдчүүдийн тоо 4,5 сая-д хүрсэн байв. Сүүлийн үед Германы том том компаниуд, тэдний араас жижиг, дунд пүүсүүд ажлын байраа гадагш гаргах нь ихсэж байна. Үүний гол шалтгаан бол хөдөлмөрийн өндөр өртөг, ажлын байрны өндөр үнэ бөгөөд 2003 онд Германы аж ахуйн газруудын 1/4 нь ойрын 3 жилд үйлдвэрлэлээ гадаад руу шилжүүлж гаргана гэж мэдэгдсэн. Жишээ нь Германы дэлхийд нэртэй "Сийменс" концерний охин компани "Сиймэнс Ай-Си-Эн" сүүлийн 3 жилд Хятад, Солонгос, Чех, Унгар зэрэг орнуудад үйлдвэрлэлээ шилжүүлснээр Герман дахь ажлын байраа 20.000-аар хорогдуулжээ. Энэ нь байнгын шинж чанартай болж буй ажээ. Германд капиталын гадагш гаралт 2001 онд 26,69 тэрбум евро, 2003 онд 55 тэрбум еврод хүрсэн байна.³

Герман улсад хөрөнгө оруулалт идэвхгүй, сул байгаа бөгөөд сүүлийн 3 жилд тоног төхөөрөмжид хийх хөрөнгө оруулалт 3%-8%-иар буурсан бол барилга угсралтын салбарт үүнээс ч дор байв. Шинжлэх ухаан, техник, технологийн шинэчлэлд зарцуулах зардал ДНБ-тэй харьцуулан үзэхэд өсөлтгүй байна.

¹ *Вестник Европы, XV том, 2005, 69 дүгээр тал*

² *мөн тэнд*

³ *мөн тэнд*

Ийм таагүй нөхцөл байдалд Шредерийн Засгийн газар өөрчлөлт шинэчлэлээ хийж эхэлсэн юм. Хэдийгээр өөрчлөлт, шинэчлэлийн хөтөлбөрийг 80-аад оны сүүлчээр Х.Колийн Засгийн газар эхлүүлсэн ч цогц арга хэмжээ болж чадаагүй байлаа. Засгийн эрхэнд гарангуут Шредер өөрчлөлт шинэчлэлийг цогцоор нь хараахан хийж эхлээгүй үед олон асуудалтай тулгарсан бөгөөд өөрчлөлтийг зөвхөн эдийн засаг, нийгмийн салбар руу чиглүүлэн хязгаарласны зэрэгцээ татвар болон тэтгэврийн өөрчлөлтийг зэрэг хийхээр бэлтгэж эхэлсэн байв. Зөвхөн 2001-2002 оны эдийн засгийн уналт л түүнийг өөрчлөлт шинэчлэлийг цогцоор нь хийхэд хүргэсэн байна.

2003 оны III сарын 14-нд Засгийн газар Бундестагт тусгай мэдэгдэл хийсэн нь хожим "2010 он-цаг үеийн асуудал" хэмээх өөрчлөлтийн хөтөлбөрийг бий болгожээ. Анхандаа уг хөтөлбөр нь дараах үндсэн арга хэмжээг багтааж байв. Үүнд:

нэгдүгээрт, хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлт

хоёрдугаарт, эрүүл мэндийн зайлшгүй даатгалын өөрчлөлт

гуравдугаарт, гар урлалын үйлдвэрлэлийн хууль эрхзүйн зохицуулалтын өөрчлөлт, нийтийн аж ахуйн санхүүгийн шинэчлэлт, орон нутгийн засаг захиргаанд зориулсан хямд зээлийн хөтөлбөр ба орон сууцны шинэчлэл зэрэг юм.

Хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлт нь хоёр үндсэн арга хэмжээг багтааж байв. Үүнд үндэслэлгүйгээр ажлаас халахын эсрэг уян хатан хамгаалалт хэрэглэх ба ажилгүйдлийн тэтгэмжийг хэмжээ болон хугацаагаар нь зохицуулах явдал орно. Мөн удаан хугацаагаар ажилгүй байсан тохиолдолд тэтгэмж болон нийгмийн тусламжийг тус тусад нь олгохыг зогсоож нэгтгэх тухай заажээ.

Эрүүл мэндийн зайлшгүй даатгалын хувьд үзүүлэх үйлчилгээний жагсаалт цөөрсөн байв. Мөн эмнэлэгт хэвтэх, эм худалдан авах зэрэг зарим үйлчилгээнд мөнгө нэмж төлөх тухай тусгай нэмэгдлүүд орсон байна. Энэ тогтолцоо 2004 оноос үйлчилж эхэлсэн бөгөөд сүүлийн үед интернет-аптекуудад зөвшөөрөл өгснөөр тэд хүчээ авч эхэлсэн нь ажиглагдаж байна.

Гар урлалын үйлдвэрлэлийн хуулинд зохицуулснаар гар урлалын үйлдвэрлэл нээх, худалдан авах явдал нэлээд либералчлагдахаар болж аливаа шат дамжлага багасах ажээ. Үүний зэрэгцээ татварын шат дараалсан шинэчлэлийг сэргээсэн байна.

2004 оны I сард эхэлсэн хоёрдугаар үе шат нь хүн амын албан татварыг бууруулахад чиглэжээ. Хүн амын албан татвар болон

корпорацийн татварын шинэчлэлтэй хамт улсын төсвөөс үзүүлэх хөнгөлөлтүүдийг санхүүжүүлэх явдал буурч эхэлжээ.

Ерөнхийдөө “2010 он- цаг үеийн асуудал” хөтөлбөрийн агуулга сүүлийн жил гаруй хугацаанд улам өргөжиж, шинэчлэгдэн өөрчлөгдөх шаардлагатай бараг бүх цогц асуудлууд хөтөлбөрт тусгагдсан байна. Үүнд ажилгүйдлийн тэтгэмжийг эрс багасгахаар болжээ. Өөрчлөлтөөс өмнө ажилгүйдлийн тэтгэмж олгох дээд хугацаа 36 сар байсан бол одоо ахимаг насныханд 18 сар, дийлэнх ажилгүйчүүдэд бол 12 сар болсон байна. Тэтгэмжийн дундаж хэмжээ сүүлийн цалингийн 60%-иас (өмнө нь 70%-75% байв) хэтрэхгүй байх бөгөөд ингэснээр хүмүүсийг удаан хугацаагаар ажилгүй байх сонирхлыг бууруулах, цалин нь нийгмийн тусламж, тэтгэмжээс бага ч болов илүү тул ажил хийх эрмэлзэлтэй болгох бодлого баримтлаж байгаа юм. Үнэндээ энэ нь компаниуд ажлын байраа гадагш гаргах үйл явц идэвхжиж байгаа үед нилээд эргэлзээтэй зүйл юм.

Эрүүл мэндийн хангамжийн салбарт мөн огцом өөрчлөлтүүд гарч байна. Энэ нь их чухал асуудал юм. Учир нь эрүүл мэндийн даатгалын зардал хэмжээгээрээ дээрээсээ хоёрт ордог бөгөөд төсвөөс эрүүл мэндийн даатгалд жилдээ 146 тэрбум евро зарцуулдаг. Гэтэл эрүүл мэндийн хангамжийг сайжруулдаггүй юмаа гэхэд зохих түвшинд хадгалахын тулд татварыг нэмэгдүүлэхээс өөр арга байхгүй ажээ.

Эцэст нь хамгийн чухал өөрчлөлт тэтгэврийн салбарт хийгдэх бөгөөд ажиллагсад болон ажил олгогчдоос гаргаж буй нийгмийн татварын дийлэнх хувийг тэтгэвэр эзэлдэг. Германд даатгалын татварыг ажиллагсад болон ажил олгогчид 50/50 хувийн харьцаатай төлдөг, зарим тохиолдолд улс бага хэмжээгээр нэмж төлдөг байна.

Хэдийгээр Германы сөрөг хүчин “2010 он-цаг үеийн асуудал” хөтөлбөрийн үр дагаврын хувьд эрс шүүмжлэлтэй хандаж байсан ч 2003 оны XII сарын Бундестаг, Бундесратын хурлаар эхний багц дийлэнх олонхийн саналаар батлагдсан юм. Бундестагт л гэхэд 90% нь дэмжсэн санал өгчээ. Гэсэн хэдий ч дайралтууд явагдсаар л байв.

Улс төрийн сөрөг хүчнийхэн Шредерийн зарим алдааг өөртөө ашигтайгаар эргүүлэн шүүмжилж байхад сонгогчид энэхүү өөрчлөлтийн утга санааг ойлгохгүй байгаа нь сонгуулийн үед ажиглагдаж байв. Сонгогчдын 73% нь (2005-V/16-ны байдлаар) Шредерийн Засгийн газар нийгмийн тэгш бус байдлыг Колийн Засгийн газраас илүүтэйгээр нэмэгдүүлсэн гэж үзэж байгаа судалгаа гарсан байна. Чухам ийм нөхцөлд Г.Шредер сонгуульд оролцож, дийлэнх олны саналыг авч чадаагүй ч тэрээр шинэчлэн өөрчлөгч-канцлер байсан гэж Германы түүхэнд үлдэх нь дамжиггүй. Үүний нэг жишээ нь одоогийн шинэ

Канцлер хатагтай А.Меркель сонгогдсоныхоо дараа гадаад орнуудаар айлчилж ирээд хийсэн мэдэгдэлдээ экс Канцлер Герхард Шредерийг эдийн засгийн шинэчлэлийн эхний алхмыг хэрэгжүүлсэнд талархал илэрхийлсэн явдал юм.

ХБНГУ-д болсон Бундестагийн Сонгуулийн дүнд Германы Социал Демократ Нам (ГСДН), Христосын Ардчилсан Нам (ХАН) хоёрын аль аль нь дийлэнх олонхийн саналыг авч чадаагүй учраас энэ хоёр нам Их эвслийн Засгийн газар байгуулах зөвшилцөлд хүрэхээс өөр замгүй болсон юм.

Их эвсэл байгуулах үйл явц бараг 6-7 хоног үргэлжилж, эцэст нь ХБНГУ-д их эвсэл байгуулагдсан. Ийнхүү Герман улсад анхны эмэгтэй Холбооны Канцлер болох Ангела Меркелийн тэргүүлсэн Засгийн газар байгуулагдан ажилдаа орсон юм.

Их эвслийн намууд төсвийн зардлыг багасгах ерөнхий стратегийн талаар тохиролцоонд хүрчээ. Зардлыг багасгах, татварыг нэмэгдүүлэх замаар үүнийг хэрэгжүүлэх гэнэ. Хамгийн өндөр орлоготой хүмүүст оногдуулах нэмэгдэл ашгийн татварыг гурван хувиар нэмэгдүүлэх бөгөөд, ашгийн татвар ч нэмэгдэх аж.

Их Эвслийн Засгийн газар хөтөлбөрөө нийтэд танилцуулах үйл ажиллагаандаа ороод байна. Улсын төсөвт хатуу хяналт, арвилан хэмнэлт тогтоох бололтой. Германыг нийгмийн баримжаатай улс хэвээр үлдээхийн төлөө Их эвсэл бололцоотой бүхнийг хийнэ гэж хатагтай Меркель хэлжээ. Их эвслийн гэрээ 200 шахам хуудастай том баримт бичиг байх боловч түүнд тусгагдаагүй асуудал бас байгаа ажээ. Социал Демократ Намын тэргүүнээр сонгогдсон М.Платцек Их эвсэл бол хайр дурлалаар бус тооцоогоор хангилсан “хосууд” гэж нэрлэв. Эвслийн хэлэлцээ хийх явц харилцах соёл байжээ. Германы хөгжлийн тогтвортой байдлын суурь бий боллоо гэж ихэнх улс төрчид үзэж байгаа бололтой. Их эвслийнхэн зөвшилцлөө Германы сайн сайхны төлөө эр зориг, энэрэнгүй сэтгэлээр ажиллах төлөвлөгөө хэмээн нэрлэжээ.

ХБНГУ-ын найм дах Холбооны Канцлер хатагтай А.Меркель 1989 оны намраас БНАГУ-ын улс төрийн тогтолцоог ардчилах зорилго бүхий “Ардчилсан өөрчлөлт” хөдөлгөөнд идэвхтэй орлцон улмаар БНАГУ-ын Засгийн газрын сүүлчийн тэргүүн Л.Де Мезиер-ийн хэвлэлийн төлөөлөгчөөр 1990 оны эхээр томилогдсоноор улс төрийн гараагаа эхэлсэн.

Тэрээр хуучин БНАГУ-ын нутаг дэвсгэрт ХАХ намын бүтцийг бий болгоход идэвхтэй ажиллаж улмаар 1990 онд ХАХ намын жагсаалтын дагуу Германы Бундестагийн гишүүн болж, 1991 онд ХАХ намын дэд даргаар сонгогдсон.

Хатагтай А.Меркель Холбооны Канцлер Х.Колийн тэргүүлсэн хоёр удаагийн Засгийн газрын гишүүнээр ажилласан бөгөөд намын хандивын асуудлаарх санхүүгийн будлианд оролцоогүй, хуучин намын удирдлагатай холбоогүй, Зүүн Германаас гаралтай тул нэр цэвэр хүн гэсэн үндэслэлээр 1998 онд ХАХ намын Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогдон намын хандивын асуудлаарх будлианыг зохицуулж намын нэр хүндийг аврах үүрэг хүлээсэн. Тэрээр намын удирдлагаас анх удаа “нам Х.Колийн үеэс салах ёстой” хэмээн зоригтой мэдэгдсэн гэдэг. А.Меркель Х.Колийн тэргүүлсэн Засгийн газарт ажиллаж байхдаа түүний итгэл хүлээсэн дотнын хүмүүсийн нэг болсон бөгөөд намын Ерөнхий нарийн бичгийн даргын хувьд намын хандивтай холбоотой санхүүгийн будлиант асуудлыг ХАХ нам болон Канцлер асан Х.Колийн нэр хүндэд тийм ч ноцтой бус байдлаар зохицуулан, богино хугацаанд шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг.

Тэрээр мөн 2004 онд ХАХ намын Бундестаг дахь бүлгийн дарга Ф.Мерцийг огцруулж бүлгийн даргын ажлыг хавсран гүйцэтгэх болсноор намын эрх мэдлийг нэг гарт төвлөрүүлсэн хэмээн шүүмжлүүлж байв. Анхны эмэгтэй Холбооны Канцлер болох хатагтай А.Меркель нь протестант шашинтай, өдгөө 51 настай, эрс шийдэмгий гялалзуур хүн гэж сэтгүүлчид бичдэг бөгөөд зарим хүмүүс түүнийг Английн Ерөнхий сайд асан М.Тэтчертэй зүйрлүүлэн “Төмөр хатагтай” гэж бичих явдал ч байдаг. А.Меркель 1954 онд Хамбург хотод төрсөн, Лайпциг хотын их сургуулийг физикч мэргэжлээр төгссөн, БНАГУ-ын Шинжлэх Ухааны Академид судлаачаар ажиллаж байхдаа шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан, орос, англи хэлээр чөлөөтэй ярьдаг хүн юм. Хатагтай Меркель ХБНГУ-ын Канцлерын хувьд гадаад бодлогын зарим тодорхой асуудлаар байр сууриа илэрхийлж эхэлж байгаа талаар гадаадын хэвлэл мэдээллээр бичих боллоо.

Меркель ХБНГУ, АНУ-ын харилцааг сайжруулж, Франц, Оростой хэт ойртсон байдлыг сулруулахыг амлаж байна” хэмээн Британийн Гардиан сонинд бичсэн байна. Эндээс харвал Германы хуучин Канцлер Шрёдерийн үед Иракийн дайнаас болж АНУ-тай муудаад байсан харилцааг хамгийн түрүүнд засах бололтой.

Мөн тэрээр Москвагаас зай барьж, Францын Ерөнхийлөгч Жак Ширактай хэт түншилсэн тогтолцоог өөрчлөх эрмэлзлэлтэй байж магад. Бас Европын Холбооны шинэ гишүүн орнуудтай ялангуяа Польштой сайн харилцааг тогтоохын төлөө ажиллах бололтой. Канцлерын хэлснээр ХБНГУ нь Европт “дундаж” бодлого явуулж, өөрийн үндэсний сонирхол болон өсөн тэлж буй Европын Холбоо хоёрын хоорондын тэнцвэрийг хадгалж байхыг хичээх аж. А.Меркель Канцлераар сонгогдсоныхоо

өрдөө маргааш нь гадаад айлчлалаа хийх болсон юм. Герман-Францын харилцааны "ондооширол"-ыг арай багасгаж, Европын жижиг орнуудтай холбоогоо сайжруулна хэмээн амласан А.Меркель Холбооны шинэ канцлерын хувьд анхныхаа гадаад айлчлалаа Парисаас эхэлсэн юм. Тэрээр дараа нь Бельги, Лондонд айлчилсан билээ.

Германы парламентын сонгуулийн сурталчилгааны үеэр тэрбээр Европын Холбооны жижиг орнуудтай харилцахын оронд Францын Ж.Ширак, Оросын В.Путин хоёртой "тусгай" маягийн нөхөрлөл бий болгосон гэж өөрийн өрсөлдөгч Г.Шредерийг шүүмжилж байжээ. Гэвч А.Меркелийн Эвслийн шинэ засгийн гзарын мөрийн хөтөлбөрт Паристай түншлэхийг Европыг урагш жолоодоход тун чухал хүчин зүйл хэмээн үзсэн байна. Бас Гадаад хэргийн шинэ сайд Франк-Уолтер Штайнмайер нь Г.Шредерийн ойр дотнын бөгөөд ГСДН-ын хүн юм. Энэ бүхнээс үлэхэд Германы гадаад бодлого цаашид хэвээр үргэлжлэх үндэстэй хэдий ч Германы анхны эмэгтэй Канцлер Вашингтонтой холбоогоо дажгүй бэхжүүлэх сонирхолтой байгаа нь АНУ-ын толгойлсон Иракийн дайныг тууштай эсэргүүцэж ирсэн Г.Шредерийн байр сууринаас ялгагдах бололтой. Гэхдээ тэрбээр саяхан ХБНГУ Иракт цэргээ илгээхгүй гэдгээ мэдэгдсэн билээ. А.Меркель энэ ондоо багтаж Польшт айлчилж, улмаар Вашингтон Москвад очих бодолтой байгаа гэдгийг ХАХ нам болон ГСДН-ын хамтран байгуулсан Эвслийн Засгийн газрын эх сурвалжууд нотолжээ. Германы Их эвслийн засгийн газар, илангуяа Холбооны Канцлер А.Меркелийн өмнө асар том хариуцлага тулгарч байна. Эвслийнхэн хэр эвтэй бүтээлч ажиллана Г.Шредерийн хэрэгжүүлж эхэлсэн бүтцийн өөрчлөлт, эдийн засгийн шинэчлэлтийн программыг шуурхай оновчтой зоримог хэрэгжүүлж, Германы ард түмний ирээдүйдээ итгэх итгэлийг идэвхжүүлж, өнөөгийн түр зуурын эдийн засгийн бэрхшээлийг хир эрсдэл багатай давж чадахаас ХБНГУ урьдын адил Европын болон дэлхийн тэргүүлэгч орон байх эсэх онц хариуцлагатай асуудал шийдэгдэх болж байна.